

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 30 -НИЙ  
ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

2023 оны 10 дугаар сарын 30

Улаанбаатар хот

№	Товч агуулга	Хэрэгжилт ирүүлэх байгууллагууд
1	Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хот, нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын машин, тоног, төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгаж,нарийвчилсан тоон судалгааг яаралтай гаргаж танилцуулах	✓ Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
2	Дүүргийн хэмжээнд хэчнээн км үерийн ус зайлуулах, далан, суваг, шуудууг хүчитгэх төсөв, тооцоо, судалгааг гаргаж танилцуулах.	✓ Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс ✓ Санхүү,Төрийн сангийн хэлтэс
3	БНХАУ-руу явж хот, нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа машин, тоног, төхөөрөмжийг нарийвчлан судалж, дараагийн долоо хоногийн шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах	✓ Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
4	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ цаашид “гудамжны хоол” үйлчилгээ, үйл ажиллагаа явуулахдаа нийтийн бие засах газарт нь уялдуулах, эсвэл зөөврийн шинэ технологийг судлах ажлыг зохион байгуулах	✓ Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс
5	Авто замын нэгдүгээр эгнээний зам дагуу газраа зориулалтын бусаар ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд газрын зөрчил арилгах мэдэгдэл хүргүүлж , газрыг цуцлах ажлыг зохион байгуулах	✓ Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс ✓ Чингэлтэй дүүргийн газар зохион байгуулалтын алба ✓ Хууль зүйн хэлтэс

2023 оны 11 дугаар сарын 02 -ний өдрийн 12:00 цагт багтааж, гарын үсэг, тамга тэмдэг дарж баталгаажуулан цаасаар болон файл / Мэргэжилтэн Бямбасүрэнгийн егр хаяг/-аар ирүүлнэ үү.

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 30-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 10 дугаар сарын 30

Улаанбаатар хот

№	Үүрэг даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	<b>Үүрэг даалгавар НЭГ:</b> Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хот, нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын машин, тоног, төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгаж, нарийвчилсан тоон судалгааг яаралтай гаргаж танилцуулах.			
1	<p>Хот, нийтийн аж ахуйн чиглэлээр 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажил дүүргийн хэмжээнд бүрэн хангагдан ажиллаж байна</p> <p><b>Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК Машин техник: нийт 70 машин техник хэрэгсэлтэй</b></p> <ul style="list-style-type: none"><li>- хог тээвэр - 53</li><li>- Давс бодис цацах камаз - 8,</li><li>- Цас үлээгчтэй, давс цацагчтай зориулалтын машин - 2</li><li>- Цас ачих зориулалтаар ковш - 2</li><li>- Грейдэр - 1,</li><li>- Экскаватор -1,</li><li>- Авто замын нуух шүүрдэх шүүрдэгч машин - 3</li></ul> <p><b>Найши трейд ХХК Машин техник: нийт 17 машин техник хэрэгсэлтэй</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Хог тээвэр-12</li><li>- Зам шүүрдэгч /жижиг/ -1</li><li>- Давс цацагч машин 2,5 тн-1</li><li>- Давс цацагч машин 8 тн-1</li><li>- Ковш-2 гэсэн машин, тэхник хэрэгслийн баэлэн байдлыг тус тус ханган ажиллаж байна.</li></ul> <p>Мөн дээр машин техникийн нарийвчилсан судалгааг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн Д.Дөлгөөнд viber хаягаар 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлсэн болно.</p>			

**Үүрэг даалгавар ХОЁР:** Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэртээ цаашид “гудамжны хоол” үйлчилгээ, үйл ажиллагаа явуулахдаа нийтийн бие засах газарт нь уялдуулах, эсвэл зөөврийн шинэ технологийг судлах ажлыг зохион байгуулах.

2	Дүүргийн нутаг дэвсгэрт “гудамжны хоол” үйлчилгээ, үйл ажиллагаа явуулахдаа ойролцоох аж ахуйн нэгж байгууллагуудтай тохиролцон бие засах газрыг шийдвэрлэн ажилладаг.			
---	--	--	--	--

**Үүрэг даалгавар ГУРАВ:** Авто замын нэгдүгээр эгнээний зам дагуу газраа зориулалтын бусаар ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд газрын зөрчил арилгах мэдэгдэл хүргүүлж , газрыг цуцлах ажлыг зохион байгуулах

3	Авто замын нэгдүгээр эгнээ, явган хүний зам дээр газраа зориулалтын бусаар ашиглаж үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст 3/2600 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан. Үүнд авто засвар 5, дугуй засвар 2, авто угаалга 1, сэлбэг худалдаа 1 нийт 9 газар зориулалтын бусаар үйл ажиллагаа явуулж байна. Дүүргийн Засаг даргын захирамжаар Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн дүүргийн газрын алба авто замын нэгдүгээр эгнээний зам дагуу үйл ажиллагаа явуулж байгаа 19 аж ахуйн нэгжид зөрчил арилгах тухай хугацаатай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн. Ажлын хүрээнд шат дараатай арга хэмжээг авч ажиллахаар цаашид төлөвлөж байна.			
---	---	--	--	--

ТАНИЛЦСАН:  
ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХЭЛТСИЙН ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.ГООМАРАЛ

НЭГТГЭСЭН:  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.БЯМБАСҮРЭН